



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 5/25

Хэрлэн сум

Б.Баасанжавыг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43.3, 43.3.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байгаа Батсуурийн Баасанжавыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2.Б.Баасанжавын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч
	Д.Энхтуяа	Архив, бичиг хэргийн эрхлэгч

3.Б.Баасанжавын цалинг ТЗ-8 зэрэглэлээр тогтоож, үндсэн цалинг 853,375 (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийн 20 хувир тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Баасанжавт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР